



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/55

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а" 29.1.5-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.17, 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын Их Хурлын 2021 оны "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 39 дүгээр тогтоолын 1.5 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн боловсролын салбарын ариун цэврийн байгууламжийн дэлгэрэнгүй судалгаа гаргах, тулгамдаж буй асуудал болон ашиглалт, үйлчилгээний асуудлыг шийдвэрлэх, төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, тайлагнах, хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Өнөрцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	С.Мөнхцэцэг	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
	Д.Баярхүү	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга

2. Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо болон Боловсрол, шинжлэх ухааны яамны ажлын хэсгүүдэд дэмжлэг үзүүлэн, мэдээллийг

231010165

2.

шуурхай солилцож, ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг бо тгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ